



**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

**Сарын үйл ажиллагааны үр дүнгээр
шагналт цалин олгох журам батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Зорчигч тээвэр дөрөв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 15.1.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Зорчигч Тээвэр Дөрөв” ОНӨААТҮГ-ын ажилчдад “Сарын үйл ажиллагааны үр дүнгээр шагналт цалин олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Сарын үйл ажиллагааны үр дүнгээр шагналт цалин олгох журам”-ын дагуу тухай бүр тооцож олгохыг Санхүү бүртгэлийн хэлтэс /Н.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Э.Энхтөр/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



С.БЯМБАСҮРЭН

“Зочигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын
Захирлын 20...оын дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГЭЭР ШАГНАЛТ ЦАЛИН ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Зорчигч Тээвэр Дөрөв” ОНӨААТҮГ-ын ажилтны ажил гүйцэтгэх үр чадвар, идэвх санаачилгыг дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор сарын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг тогтоож үнэлэх шагналт цалин олгоход энэхүү журмаар зохицуулна.

1.2. Ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан байдлыг харгалзан ёс зүйн зөрчилгүй, тухайн сард сахилгын шийтгэлгүй ажилтанд хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдлийг олгоно.

1.3. Тухай жилийн батлагдсан төсөвт багтаан ажилтны сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдлийг тогтоож, үндсэн цалингийн 25 хүртэл хувиар тооцож сар бүр олгоно.

1.4. Үр чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтална.

ХОЁР. САРЫН ҮР ДҮНГИЙН ШАГНАЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ

1.1. “Зорчигч Тээвэр Дөрөв” ОНӨААТҮГ-ын захирал хэлтсийн даргыг, хэлтсийн дарга өөрийн харьяалах ажилтан тус бүрийн сарын ажлыг батлагдсан маягтын дагуу дүгнэж, үндсэн үзүүлэлтийн биелэлтийг нэгтгэн тухайн сарын 25-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлнэ.

1.2. Захиргаа удирдлагын хэлтэс шагналын үндсэн үзүүлэлтийн биелэлтийг нэгтгэн газрын хэмжээнд олгох сарын үйл ажиллагааны үр дүнгийн шагналын хувь хэмжээний саналыг боловсруулан тухайн сарын 25-ны өдрийн дотор Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ.

1.3. Сарын үйл ажиллагааны үр дүнгийн шагналт цалингийн хувь хэмжээг үндсэн цалингаас бодож сарын сүүлийн цалинтай хамт олгоно.

ГУРАВ. САРЫН ҮР ДҮНГИЙН ШАГНАЛ ОЛГОХ

3.1. Үндсэн ажилтнаар томилогдсон тушаал гарснаас хойш тооцож олгоно. Туршилтын хугацаанд ажиллаж буй ажилтны шагналт цалинг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргын бичгээр гаргасан саналын дагуу олгож болно.

3.2. Үнэлгээг ажилчдад танилцуулсан байна.

3.3. Ажилтанд “хангалтгүй” гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ.

3.4. Ажилтан сарын үйл ажиллагааны шагналт цалингийн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд холбогдох тайлбар, өргөдлөө Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлж болно.

ДӨРӨВ. САРЫН ҮР ДҮНГИЙН ШАГНАЛТ ЦАЛИН ОЛГОХГҮЙ БАЙХ ҮНДЭСЛЭЛ

4.1. Шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноо 60 оноо хүрэхгүй бол;

4.2. Туршилтаар ажиллах хугацаанд;

4.3. Тус газрын захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан;

ТАВ. НЭМЭГДЭЛ ТООЦОХ ҮНЭЛГЭЭ, ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Нийт үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	90-100	25 хувь
2	80-89	20 хувь
3	70-79	15 хувь
4	60-69	10 хувь

ТАВ. БУСАД

5.1. Энэхүү журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд холбогдох албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.